БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГА..... С.ЦАГААНБААТАР

“Ахмадын өргөө” цомцог гэр барих ажлын даалгавар

2025 оны 07 сарын 01-ны өдөр *Цээл сум*

1. Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон дугаар:	Ахмадын өргөө барих ТӨАЦСЗДТГ/20250101022
2. Үндэслэл	Цээл сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2-р хуралдаанаар баталсан.
3. Байршил	Төв аймгийн Цээл сум, Талын хайрханы 2-р баг
4. Захиалагч	Цээл сумын Засаг даргын тамгын газар
5. Хөрөнгө оруулагч байгууллага	Цээл сумын Засаг даргын тамгын газар-Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
6. Төсөвт өртөг /төгрөг/	Нийт: 130.000.000 /нэг зуун гучин сая төгрөг/ Багц 1: Цомцог гэр барих - 86,000,000 /наян зургаан сая төгрөг/
7. Ажил гүйцэтгэх хугацаа	Тендерт шалгарч гэрээ байгуулснаас хойш 35 хоногийн хугацаанд барьж захиалагчид хүлээлгэн өгнө.
8. Баталгаат хугацаа	Тухайн ажлын баталгаат хугацаа 3 жил байх ба ямар ажил, гүйцэтгэл дээр баталгаа гаргахаа хоёр тал гэрээ байгуулах явцад тохиролцож гэрээнд тусгана.
9. Зорилго, ач холбогдол	Ахмад атарчдыг алдаршуулах, сумын нийтийг хамарсан аливаа үйл ажиллагааг зохион байгуулах.
10. Зориулалт, хүчин чадал	12 диаметрийн хэмжээтэй, ханын өндөр 2.4м-ээс багагүй, 1 ээлжээр 100-120 хүн хүлээн авах хүчин чадалтай, хурал, цуглаан уулзлат, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах зориулалттай.
11. Цомцог гэрт тавигдах шаардлага	**<u>Ерөнхий шаардлага:</u>** • Овор хэмжээ: Цомцог гэрийн хамгийн өндөр цэг нь 5 метрээс багагүй өндөртэй, 12 диаметрээс багагүй хэмжээтэй, дулаалгатай бетонон суурьтай байна. • Гэрийн ерөнхий бүтэц нь төмөр карказан бүтээцтэй байх ба шаардлагатай хэсэгт модон бэлдэц орж болно. • Дулаалга нь эрдэс хөвөн болон бусад насжилт өндөртэй, чанартай материал байна. • Дотор талаас монгол гэрийн унь, хана, тооно, баганатай, гоёлын интерьер дизиан сайтай байх ба угааж цэвэрлэхэд хялбар байна. • Гадна талаас монгол гэр адил харагдах ба бүрээс нь ус чийг нэвтрэхгүй, өгөрч гандахгүй насжилт сайтай мембрам материалаар хийсэн байна.

	<u>Үйлчилгээний байрны үзүүлэлт:</u> • Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах стандартыг хангасан дуу чимээ шингээх, орчны болон байгалийн гэрэл сайн нэвтрэх, тусгаарлах зориулалттай байна. Дотор гэрэлтүүлэг нь маш сайн чанарын гоёлын гэрэлтүүлэг байна. • Цахилгаан хангамж, агааржуулалтын систем, халаалтын системтэй байна. • Гал түймрийн аюулаас хамгаалах арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. • Гадна тохижилт: хашаатай, гэрэлтүүлэгтэй байх, • Холбоо, дохиоллын системтэй, • Хяналтын камераар тоноглогдсон байх, • Агааржуулалтын системтэй байх • Хана нь усан дусал, уур үүсдэггүй, цан цохидоггүй, дулаанаас хамаарсан агшилт, тэлэлт явагддаггүй байх ба монгол гэрийн ханатай адил харагдахаар байна. • Тааз нь тоос шороо, уур, цан хуримтлагдахааргүй, будаг, шохой нь хуурч унахааргүй, хөгц мөөгөнцөр үүсэхээргүй монгол гэрийн унь дээвэртэй адил харагдахаар байна. • Цонх нь битүүмжлэл сайтай, нягт хаагддаг, нисдэг шавж орохоос урьдчилан сэргийлж торон хаалттай, 3 давхар шилтэй сайн чанарын вакум цонх байна. 2-өөс багагүй цонхтой байна. • Хаалга нь металл вакум хаалгатай байна. • Цахилгаанаар халдаг шалны халаалттай, аль эсвэл панелан халаалттай, паркетэн шалтай байна. • Дотроо жижиг тайзтай байна. • Тамгын газрын барилгатай хүзүүвчээр холбогдсон байна. Хүзүүвч нь гэрийн ханын өндөртэй адил өндөртэй, 3м урттай, 1,5 м өргөнтэй, гадагш гарах хаалгатай, цонхтой байна.
12. Галын аюулгүй байдлын нөхцөл	Төлөвлөж буй барилга байгууламжийн зай хэмжээг галын болон бусад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх
13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл	Шаардлагагүй.

Боловсруулсан: Засаг даргын орлогч Д.Ууганбаяр

---o0o--